



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Тохижилт үйлчилгээ УТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2024/01/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2024 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Аудитор: Б.Алтанцэцэг

Утас: 99016193 Цахим хаяг: altantsetseg6193@gmail.com

Аудиторын туслах: П.Байгальмаа

Утас: 99038857 Цахим хаяг: Baigal0508@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.04 № 117
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд үйл ажиллагааны зардалд 63.2 сая төгрөг зарцуулж, 5.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тус байгууллага нь 2023 онд орон нутгийн төсвөөс 57.6 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт бийш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	744,500.00	4,523,707.68
1.1.2	Дансны авлага	-	
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		157,854.52
1.1.4	Бусад авлага	20,000.00	20,084.00
1.1.6	Бараа материал	1,120,000.00	1,120,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,884,500.00	5,821,646.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	
1.2.1	Үндсэн хөрөнгө	54,043,000.00	44,645,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	54,043,000.00	44,645,000.00
1.3	Нийт хөрөнгийн дүн	55,927,500.00	50,466,646.20
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.3	Татварын өр	163,400.00	300,084.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	163,400.00	300,084.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	163,400.00	300,084.00
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч	42,900,000.00	42,900,000.00
2.3.1	-төрийн	42,900,000.00	42,900,000.00
2.3.2	-хувийн	-	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	12,864,100.00	7,266,562.20
2.3.10		-	
2.3.11	Эздийн өмчийн дүн	55,764,100.00	50,166,562.20
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	55,927,500.00	50,466,646.20

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Борлуулалтын орлого (цэвэр)	33,500,000.0	57,600,000.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	33,500,000.0	57,600,000.00
8	Бусад орлого	14,123,000.0	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	34,784,000.0	63,197,537.80
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	12,839,000.0	(5,597,537.80)
19	Орлогын татварын зардал	128,400.00	
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	12,710,600.0	(5,597,537.80)
24	Орлогын нийт дүн	12,710,600.0	(5,597,537.80)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	42,900,000.00	12,864,100.00	55,764,100.00
2	Залруулсан үлдэгдэл	42,900,000.00	153,500.00	43,053,500.00
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	12,710,600.00	12,710,600.00
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
8	2023 оны 01-р сарын 01-ны үлдэгдэл	42,900,000.00	12,864,100.00	55,764,100.00
10	Залруулсан үлдэгдэл	42,900,000.00	12,864,100.00	55,764,100.00
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(5,597,537.80)	(5,597,537.80)
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	42,900,000.00	7,266,562.20	50,166,562.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	33,500,000.00	57,600,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	33,500,000.00	57,600,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	34,769,000.00	53,820,792.32
1.2.1	Ажиллагчдад төлсөн	21,041,700.00	26,260,252.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,708,600.00	6,078,757.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,579,600.00	6,827,450.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,037,880.00	2,042,727.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,401,300.00	12,611,606.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,269,000.00	3,779,207.68
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,269,000.00	3,779,207.68
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	2,013,500.00	744,500.00
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	744,500.00	4,523,707.68

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлтүүд	2023 оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн болон нэмэгдэл цалин	26,260,252.00	26,260,252.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,170,396.00	3,170,396.00	-	100.00
Бусад татвар хураамж			-	
Гэрэл цахилгааны төлбөр			-	
Бичиг хэрэг	40,700.00	40,700.00	-	100.00
Тээвэр, шатахуун	5,620,000.00	5,620,000.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,146,950.00	1,146,950.00	-	100.00
Дотоод албан томилолт			-	
Хөдөлмөр хамгаалалын зардал	-	-	-	
Сэлбэг хэрэгсэлийн зардал	980,640.00	980,640.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	15,020,000.00	15,020,000.80	(0.80)	100.00
ТУЗ зардал			-	
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	9,758,589.00		
Бусад зардал	5,329,062.00	1,200,010.00	4,129,052.00	22.52
Байгууллагын нийт зардал		63,197,537.80		
Орлого	57,600,00.00	57,600,000.00		100.00
ОРЛОГЫН ДҮН	-	57,600,000.00		
АШИГ+ АЛДАГДАЛ-	-	5,597,537.80	(5,597,537.80)	

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,819.1 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, 1 албан шаардлага, 1 залруулга хийсэн.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус байгууллага 2023 оны санхүүгийн тайланд үнэ төлбөргүй ирсэн бусад үндсэн хөрөнгө 10,2 сая төгрөг, машин тоног төхөөрөмжид 11,1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй	1	21,382.0	1	21,382.0	0.0	0.0	1	21,382.0	0.0	0.0	0.0	0.0
Дүн	1	21,382.0	1	21,382.0	0.00	0.00	1	21,382.0	0.00	0.00	0.00	0.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайланд онд барилгын засварын материалын тайланд 437.1 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, материалын зардлыг зарцуулж тайлагнасан.	1	437.1	0.0	0.0	1	437.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	1	437.1	0.0	0.0	1	437.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

